



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 17 өдөр

Дугаар А/86

Чингис хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Орон сууцны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.2, 8.2.4 дахь заалтууд, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 06 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 6.2.3 дахь зорилтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Хэнтий аймгийн хүн амыг хямд үнэтэй, чанартай орон сууцаар хангах бодлого, чиг үүргийг хэрэгжүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд орон сууцны барилга барих, бариулах ажлыг зохион байгуулах, холбогдох асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэж ажиллах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | | |
|-----------------------|----------------|---|
| Ажлын хэсгийн ахлагч: | Ц.Чогсомжав | Аймгийн Засаг даргын орлогч |
| Нарийн бичгийн дарга: | Э.Мөнх-Эрдэнэ | Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга |
| Гишүүд: | Б.Дарханбаатар | Хууль эрх зүйн хэлтсийн дарга |
| | С.Нямдаваа | Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга |
| | Д.Баярхүү | Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга |
| | Ц.Бат-Эрдэнэ | Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн |
| | О.Сэдэд | Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн |
| | Г.Мөнхжаргал | Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын Архитектор, дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн |
| | Н.Ганболд | Монгол Улсын Зөвлөх инженер /зөвшилцсөнөөр/ |

2. Ажлын хэсгийг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж, хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг аймгийн Засаг даргын удирдлагын зөвлөлд танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Ц.Чогсомжав/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ИДЭРБАТ



231010253